








ЖИЖҮҮРИЙН ҮҮРЭГ
Байрын багш,жижүүрийн үүрэг


Эцэг эхийн үүрэг
1. Иргэд нийтийн хуралд өөрийн биеэр оролцож шийдвэрлүүлсэн байх
2. Иргэдийн хурлын шийдвэрээр хяналтын тоонд багтсан хүүхдээ 8 сарын 30-31-ний өдрүүдэд авчран, захирлаас бичиг авч байранд оруулна.
3. Хүүхдүүддээ цэвэр үзэмжтэй хайрцаг, хувцас, хичээлийн хэрэгсэл, эмийн санг бэлтгэн өгсөн байна.
4. Дотуур байрын сурагчдад өгсөн зуны даалгаврыг бүрэн биелүүлэх үүрэгтэй.
5. Таны хүүхэд багийн иргэд нийтийн хурлаар гарган шийдвэрлүүлсэн нэрсийн жагсаалтанд багтаагүй тохиолдолд бид төсвөөс илүү тооны хүүхэд авах боломжгүй тул сургуулийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсан шаардлага тавихгүй байх.
6. Байранд суух хүүхдийнхээ эрүүл мэнд, ариун цэврийн талаар зохих шаардлага хангасан байх.
7. Дотуур байрын дотоод журам, сурагчийн дүрэм, сурагчийн ёс зүйн дүрэм, сургуулийн дотоод журам, хариуцлагын гэрээг уншиж судлах.


Сурагчдад хүлээлгэх хариуцлага
1. Дотуур байранд баримтлах дэгийг удаа дараа зөрчсөн.
2. Дотуур байранд хүүхэд зодож танхайрсан.
3. Архи уусан. бусдыг ямар нэгэн байдлаар дарамталсан.
4. Хулгай хийж бусад сурагчдад эд мөнгөний хохирол учруулсан.
5. Чөлөө зөвшөөрөлгүй оргон явсан.
6. Дотуур байранд эцэг эх, төрөл төрөгсдөөс бусад хүмүүс оруулж ирж эмх замбараагүй байдал үүсгэсэн.
7. Байрын болон сургууль орчны эд хогшлыг санаатайгаар эвдэж гэмтээсэн бол байрнаас хөөх хүртэл арга хэмжээ авна.


Эцэг эхийн эрх
1. Хүүхдийнхээ хоол унд, бусад нөхцөлийн талаар санал дүгнэлт хэлэх, шаардлагатай бол сургуулийн захиргаа, сумын ЗДТГ, бусад холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.
2. Сурагчийн хоолыг амталж санал зөвлөмж өгөх, шаардлага тавих.
3. Сурагчдын зуны даалгаврын зарцуулалтанд хяналт тавьж тайланг сонсохыг шаардах


Байрын багшийн эрх
1. Сурагчдын талаар гаргасан аливаа асуудлыг сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүлэх.
2. Дотуур байрын сурагчдад дотоод журманд заасан дэгийг баримтлах, тэдний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шаардлага тавих
3. Сурагчдыг дотуур байранд авах, үргэлжлүүлэн суулгах эсэх талаар саналаа хэлж шийдвэрлүүлнэ.
4. Дотоод журманд заасан ноцтой зөрчил гаргасан хүүхдийг байранд авахгүй байх.
5. Гал тогоо болон хоолны талаар хяналт тавьж шаардлага тавих
6. Дотуур байрын халаалт, гэрлийн талаар гарсан аливаа зөрчлийг арилгуулах, зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх
7. Сурагчдын эцэг эхэд хүүхдийн талаар санамж дүгнэлт хэлэх, зөвлөх, туслалцаа авах
8. Байрын дотоод журам зөрчсөн ба байранд суух боломжгүй нь нотлогдсон сурагчийг сургуулийн захиргаатай зөвшилцөн байрнаас хөөх

Сурагчдын баримтлах дэг
1. Байрын багш сурагчид доорх дэгийг чанд баримтлах үүрэгтэй.
Хүлээн авсан эд хогшил, цагаан хэрэглэлийг ариг гамтай эдэлж, байр тасгаа тохижуулан цэвэр үзэмжтэй байлгах
3. Тасгийнхаа болон бусад сурагчидтай зөв харьцаж бусдыг хүндэтгэн хандах, бусдад саад болохгүй байх
4. Байрын багшийн хяналтын доор гэрийн даалгаврыг бүрэн хийж, хичээлдээ шамдан суралцах
5. Орой 19.00 цагаас хойш чөлөө зөвшөөрөлгүй гадуур явахгүй байх
6. Тасаг коридороор хашгирах, ноцолдох, дэмий салгуулахгүй байх
7. Дотуур байрын дотоод гадаад орчинг бохирдуулахгүй байх
8. Бусдыг хэл амаар доромжлох, бусдад дарамт үзүүлэх, хүүхэд зодож танхайрах зэрэг зохисгүй байдал гаргах, хулгай хийх, оргох, тамхи татах, архи уух зэрэг зөрчил гаргахгүй байх
9. Дотуур байрын багш үйлчлүүлэгчдийн үйл ажиллагааг хүндэтгэх
10. Чөлөөгүй буюу чөлөөний хугацааг хэтрүүлэн хичээл таслахгүй байх


МАНАЙ САЙЧУУД






























НҮБ- ЫН ХҮҮХДИЙН
САНГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР
ТОХИЖУУЛАВ.